



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/838

Арвайхээр

Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 40, 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хянаж зөвшөөрөл олгосон сумын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга (М.Жамъяншарав), Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (М.Жамъяншарав)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/151 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101607

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 30-ны өдрийн 838 дугаар
захирамжийн хавсралт

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Тамгын газрын дарга	1
4.	Санхүүгийн албаны дарга	1
5.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	1
6.	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	1
7.	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8.	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	1
9.	Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
10.	Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Нийгмийн ажилтан	1
13.	Нягтлан бодогч	1
14.	Багийн Засаг дарга	5
15.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
16.	Нярав	1
17.	Үйлчлэгч	1
18.	Жолооч	1
Бүгд		22